



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН  
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН  
ТУШААЛ

2025 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 1/193

Улаанбаатар хот

Сургалт, судалгааны төв байгуулах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.9.12, 4.9.16 дахь заалт, ШУТИС-д судалгааны төв байгуулж, ажиллуулах нийтлэг журмын 7.1 дэх заалт, Эрчим хүчний инженерчлэлийн сургуулийн санал, ШУТИС-ийн Ректорын зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Сэргээгдэх эрчим хүчний туршилт, үйлдвэрлэлийн парк” төвийг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс байгуулж, дүрмийг хавсралтаар баталсугай.
- “Сэргээгдэх эрчим хүчний туршилт, үйлдвэрлэлийн парк” төвд гэрчилгээ олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, инновац эрхэлсэн проректор (Д.Цолモンбаатар), Инновац, бизнес түншлэлийн албаны дарга (М.Зулбаяр) нарт даалгасугай.

РЕКТОР



Т.НАМНАН

367040975

	<p>“Сэргээгдэх эрчим хүчний судалгаа хөгжүүлэлтийн парк” төвийн дүрэм</p>	<table border="1"> <tr> <td>Эхний хэвлэлт</td><td>2025.06.06</td></tr> <tr> <td>Өөрчилсөн огноо</td><td></td></tr> <tr> <td>Өөрчлөлтийн дугаар</td><td></td></tr> </table>	Эхний хэвлэлт	2025.06.06	Өөрчилсөн огноо		Өөрчлөлтийн дугаар	
Эхний хэвлэлт	2025.06.06							
Өөрчилсөн огноо								
Өөрчлөлтийн дугаар								

## “Сэргээгдэх эрчим хүчний туршилт, үйлдвэрлэлийн парк” төвийн дүрэм

Боловсруулсан:

Эрчим хүчний инженерчлэлийн сургууль

Хянасан:

ШУТИС-ийн Инновац, бизнес түншлэлийн алба

Дэмжсэн:

ШУТИС-ийн РЕКТОРЫН ЗӨВЛӨЛ

Баталсан:

ШУТИС-ийн РЕКТОР



ШУТИС-ийн Ректорын 2025 оны 06 дугаар сарын  
06-ны өдрийн 11:00 дугаарт тушаалын хавсралт

**“СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУРШИЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ПАРК”-ИЙН ДҮРЭМ**  
**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. “Сэргээгдэх эрчим хүчний туршилт, үйлдвэрлэлийн парк” нь (Цаашид “Төв” гэх) Монгол улсын Шинжлэх ухаан, технологийн их сургууль (Цаашид “ШУТИС” гэх)-ийн Эрчим хүчний инженерчлэлийн сургуулийг түшиглэн үүсгэн байгуулсан технологийн судалгааны төв юм.
- 1.2. Төвийн үйл ажиллагааг Монгол Улсын Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Инновацийн тухай хууль болон бусад эрх зүйн акт, ШУТИС-ийн Дүрэм, тэдгээртэй нийцүүлэн баталсан Төвийн дүрмээр зохицуулна.
- 1.3. Төвийн эрхэм зорилго нь Монгол улсын хэмжээнд шилдэг мэдлэг, чадвар бүхий судалгааны баг, хамт олныг нэгтгэн олон улсад өрсөлдөхүйц, нарийн технологи, мэдлэг шингэсэн үндэсний бүтээгдэхүүн бий болгоходо дэвшилтэй технологийн судалгаа хийх өндөр чадавхтай мэргэжилтэн бэлтгэх замаар өндөр технологи хөгжүүлэх, нутагшуулах, дамжуулах юм.
- 1.4. Төв нь Монгол улсын сэргээгдэх эрчим хүчний салбарт шинэ мэдлэг бүтээж, эрдэм шинжилгээ судалгааг эрчимжүүлж, үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг өргөжүүлэн инновацийг хөгжүүлэх зорилготой ажиллана.
- 1.5. Энэхүү дүрмийг Төвийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулахад чанд мөрдөнө.
- 1.6. Төвийн оноосон нэр нь монголоор “Сэргээгдэх эрчим хүчний туршилт, үйлдвэрлэлийн парк”, товчилсон нэр нь “ШУТИС-СЭХТҮП”, англиар “Renewable Energy Research and Development Park” гэх ба товчилсон нэр нь “RER&D park MUST” байна.
- 1.7. Төв нь Монгол улс, Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хороо, “ШУТИС-ийн Сэргээгдэх эрчим хүчний туршилт, үйлдвэрлэлийн парк” гэсэн хаягт байрлана.
- 1.8. Төв нь өөрийн үйл ажиллагаандaa баталгаажсан лого, албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.
- 1.9. Төвийн үйл ажиллагаа нь ШУТИС-ийн Эрчим хүчний инженерчлэлийн сургуулийн бүтцэд харьялагдах ба Эрдэм шинжилгээний нэгж байгууллагын гэрчилгээ олгогдоноор хүчин төгөлдөр болно.

Хоёр. Төвийн бүтэц, зохион байгуулалт

- 2.1. Төвийн захирлыг ШУТИС-ийн ректор, холбогдох бүрэлдэхүүн сургуулийн удирдлагатай зөвшилцөн 2 жилийн хугацаатайгаар томилох ба дахин 2 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн ажиллуулж болно.
- 2.2. Төвийн захирал нь төвийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, их сургуулийн дүрэмд заасан холбогдох үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 2.3. Төвийн бүтэц бүрэлдэхүүн, орон тоо, цалингийн сүлжээг төвийн захирал тодорхойлж, харьяалагдах салбар сургуулийн захирлаар батлуулж ажиллана.
- 2.4. Төвийн захирал нь төвийн үндсэн болон гэрээт ажилтнуудыг сонгон шалгаруулж, ажилд авах болон ажлаас чөлөөлөх санал гаргах ба харьяалагдах бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар шийдвэрлүүлнэ.
- 2.5. Төв нь ШУТИС-ийн холбогдох мэргэжлийн профессор, багш нар, гадаадын их сургуулийн профессор, багш нарыг урилгаар, бусад судлаач, ажилтан, ажиллагсдыг гэрээгээр ажиллуулж болно.

Гурав. Төвийн үйл ажиллагаа

- 3.1. Төв нь сэргээгдэх эрчим хүчиний эх үүсвэрийг ашиглан эрчим хүч үйлдвэрлэл болон инновацын судалгаа хийж, түүнийг ашиглан өндөр технологийн бүтээгдэхүүн гаргах чиглэлээр дараах үйл ажиллагаа явуулна. Үүнд:
  - 3.1.1. Нарны цахилгаан станц, цэнэг хуримтлуурын байгууламжийг ашиглан эрчим хүчиний үйлдвэрлэл, судалгааны жишиг лаборатори байгуулах;
  - 3.1.2. Төв нь бие даан болон гадаад, дотоодын бусад байгууллагуудтай хамтран олон улсын, улсын төсвийн, бизнесийн байгууллагын санхүүжилттэй шинжлэх ухаан, технологи, инновацын судалгааны төсөл хэрэгжүүлэх, гэрээт ажил гүйцэтгэх;
  - 3.1.3. Нарны цахилгаан станц, цэнэг хуримтлуурын байгууламж болон бусад тоноглол, төхөөрөмжүүдийг ашиглан судалгааны ажил гүйцэтгэж, инновацын бүтээгдэхүүн гаргаж, үйлдвэрлэлийн технологи, аргачлал боловсруулах;
  - 3.1.4. Инновац, технологи дамжуулалт, сургалт-судалгаа-үйлдвэрлэл-бизнесийн инкубатор хөгжүүлэх;
  - 3.1.5. Судлаач, судалгааны багийг солилцох;
  - 3.1.6. Холбогдох хөтөлбөрөөр судлаач магистр, докторын сургалт, дадлагын болон эрдэм шинжилгээний ажлыг дэмжин оролцож, өндөр чадвартай судлаач бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх;
  - 3.1.7. Судалгааны ажлын үр дүнд тулгуурлан холбогдох чиглэлээр мэргэшүүлэх сургалт зохион байгуулах;



- 3.1.8. Олон улсын эрдэм шинжилгээний хурал, семинар болон үйлдвэрлэлийн технологийн сургалт, дадлага, судалгааны ажил зохион байгуулах;
- 3.1.9. Гадаад, дотоодын хамтын ажиллагааг хөгжүүлж Монгол орны сэргээгдэх эрчим хүчний нөөцийн үнэлгээ, нөөцийг ашиглах чиглэлээр эрдэм шинжилгээний судалгааны ажлын үр дүнг олон улсын түвшний сэтгүүлд хэвлүүлж Монгол орныг дэлхийн тавцанд сурталчлах зэрэг болон бусад үйл ажиллагааг явуулна.
- 3.2. Төв нь явуулж буй үйл ажиллагааны тайланг жил тутам харьяа сургуулийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлнэ.
- 3.3. Төвийн санхүүжилт нь нарны цахилгаан станц болон цэнэг хуримтлуурын байгууламжийг ашиглан үйлдвэрлэж, борлуулсан эрчим хүчний орлого болон улс, олон улсын төсвийн санхүүжилттэй төсөл, төвөөс явуулсан ажил, үйлчилгээний төлбөр, төсөл, гэрээт ажлын хэлс, сургалт, судалгаа болон өөрийн үйл ажиллагааны бусад орлого, эх үүсвэрээр санхүүжиж ажиллана.
- 3.4. Төв нь санхүүгийн үйл ажиллагааг бүрэлдэхүүн сургуулийн дансыг ашиглан явуулна.
- 3.5. Төвийн захирал болон ажилтнуудад олгогдох цалин, урамшуулал нь төслийн удирдагч, төвийн захирал нарын тодорхойлолтыг үндэслэн төвийн өөрийн орлогоос, батлагдсан хэмжээгээр олгогдоно.
- 3.6. ШУТИС-ийн профессор, багш нар төвийн орон тоонд ажилласан тохиолдолд цалин, хэлс, нэмэгдлийг зөвхөн төвийн орлогоос олгоно.
- 3.7. Төвийн санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл, тайланг холбогдох сургуулийн нягтлан бодогчид хариуцан гүйцэтгэх бөгөөд холбогдох цалин хөлсийг төвийн үйл ажиллагааны орлогоос олгож болно.
- 3.8. Төвийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон лаборатори, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь ШУТИС-ийн өмчид бүртгэгдэх бөгөөд, бий болсон оюуны бүтээл нь ШУТИС-ийн оюуны өмч байна.
- 3.9. Төвийн үйл ажиллагааны тайлан мэдээг ШУТИС-ийн мэдээллийн нэгдсэн санд тухай бүрд тогтмол оруулж ажиллана.

#### Дөрөв. Төвийн эрх, үүрэг

- 4.1. Төв нь өөрийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах дэмжлэгийг ШУТИС-ийн нэгж байгууллагуудаас авах эрхтэй.
- 4.2. Төв нь батлагдсан журмын дагуу эрдэм шинжилгээ, туршилт, лабораторийн багаж хэрэгслийг гэрээний үндсэн дээр гаднын байгууллагаас авч ашиглах буюу гаднын байгууллагуудад гэрээгээр ашиглуулж болно.

- 4.3. Төв өөрийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон орлогоос “ШУТИС-д судалгааны төв байгуулж, ажиллуулах журам”-д заасан хувь хэмжээгээр зохих шимтгэлийг Судалгааг дэмжих санд төвлөрүүлэх үүрэгтэй.
- 4.4. Төв нь гадаад, дотоодын байгууллагуудтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ гэрээнд заасан хугацаанд нь бүрэн биелүүлнэ.
- 4.5. Төв нь үйл ажиллагаандаа их сургуулийн захиргаа, санхүүгийн болон эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, гэрээт ажил гүйцэтгэх дүрэм, журмуудыг мөрдөж ажиллана.

#### Тав. Төвийн хариуцлага

- 5.1. Төвийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг төвийн захирал, харьялагдах бүрэлдэхүүн сургуулийн захирал үр дүнгийн гэрээ байгуулан баталгаажуулж, биелэлтийн тайланг тогтмол тайлагнаж байна.
- 5.2. Төв 2 жил тутамд ШУТИС-ийн инновац эрхэлсэн нэгж, эрдмийн дэд зөвлөлөөр үйл ажиллагаагаа дүгнүүлж, ректорын зөвлөлд танилцуулна.
- 5.3. Төвийн захирлыг ажлын хариуцлага алдсан, алдаа дутагдал гаргасан, холбогдох хууль, дүрэм, журмыг зөрчсөн, гэрээт болон төслийн ажлын гүйцэтгэлийг хангагүй, үр дүнгийн гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд үүрэгт ажлаас нь чөлөөлөх саналыг ШУТИС-ийн Захиргаанаас гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй.

#### Зургаа. Бусад зүйл

- 6.1. Төвийн гэрчилгээний хугацаа дууссан тохиолдолд эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал гэрчилгээний хүчинтэй хугацааг 2 жилээр сунгаж гарын үсэг зурна.
- 6.2. Төвийг дараах тохиолдолд их сургуулийн Ректорын зөвлөлийн шийдвэрээр татан буулгах буюу өөрчлөн зохион байгуулна. Үүнд:
  - 6.2.1. Үүсгэн байгуулагч санал, хүсэлт гаргасан
  - 6.2.2. Аттестатчилалд хангалтгүй дүн үзүүлсэн
  - 6.2.3. Байгуулагдсанаас хойш хоёр жилийн дотор үйл ажиллагаа явуулаагүй
  - 6.2.4. ШУТИС-ийн дүрэм, нийтлэг журмыг мөрдөж ажиллаагүй
  - 6.2.5. Монгол улсын хууль тогтоомжийг зөрчсөн, хууль бус үйл ажиллагаа явуулсан
- 6.3. Энэхүү дүрэм нь Төв байгуулах тухай ШУТИС-ийн ректорын тушаал гарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

--оо--